



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/ЖС

Бөхт

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дах хэсэг, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/251 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/588 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч | Б.Мядагмаа (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч) |
| Гишүүд | Э.Сумъяа (1 дүгээр багийн Засаг дарга) |
| | Д.Шинэбаяр (2 дугаар багийн Засаг дарга) |
| | Б.Цэрэнням (Бөхт таван эрдэнэ ХХК-ны малын их эмч) |

2. Шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж, шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Тархварзүйч (Б.Мядагмаа)-д, тарилгын ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж ажиллахыг Бөхт таван эрдэнэ ХХК-ны малын эмч (Б.Цэрэнням)-д, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад үхэр сүргийг бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов мэдээг хүргэн бэлэн байдлыг хангуулахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ